

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**НЭГ. ХҮН-НИЙГМИЙН ХӨГЖИЛ**

Хүний хөгжлийг бүх талаар дэмжиж, үндэсний өв уламжлал, орчин үеийн дэвшилтэт соёлыг шингээсэн иргэдийг төлөвшүүлж, урлаг гоо зүйн боловсролыг дээшлүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулна.

Боловсрол, соёлын үйл ажиллагаанд багш, эцэг эх, суралцагсдын хамтын ажиллагааг өргөжүүлж, боловсрол олгох үйл явцыг бүх нийтийн хамтын хариуцлага болгоно.

Эрүүл мэндийн салбарын удирдлага, менежментийг сайжруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, эрүүл, аз жаргалтай амьдралыг цогцлоон бүтээнэ.

**1.1 Боловсрол:**

*Иргэдийн сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлж, суралцах, хөгжих таатай орчныг бүрдүүлэн багшийн мэргэжлийн үнэлэмж, ур чадварыг дээшлүүлж, оюунлаг, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.*

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа / он /	Хөрөнгийн эх үүсвэр	Хүрэх үр дүн
<b>1.1.1. Боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, заах аргыг сайжруулах замаар боловсролын салбарын хүний нөөцийг бэхжүүлнэ.</b>					
1	Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын үр дүнг дэмжих зорилгоор “Сайн багш” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Мэргэжлийн зэрэгтэй багш нарын хувь өсч, ажлын үр дүн бодитоор нэмэгдсэн байна.
2	Ур чадвар, ажлын амжилтаараа ялгарч байгаа багш, удирдах ажилтныг гадаад, дотоод урт, дунд, богино хугацаанд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах, Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Мэргэжил дээшлүүлсэн багш, удирдах ажилтны тоо өссөн байна.

3	Анги удирдсан болон ахмад, залуу багш нарын зөвлөгөөнийг зохион байгуулах, “Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-г ХХҮГ-тай хамтран зохион байгуулах	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	“Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-г Ахмадын зөвлөх үйлчилгээ хөтөлбөртэй уялдан хэрэгжүүлж, сум бүр “Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-ний багтай болсон байна.
4	СӨБ, ЕБС-иудыг нэн шаардлагатай дуу хөгжим, байгалийн ухааны мэргэжлийн багшаар хангах, мэргэжлийн багшийн хангалтыг 100 хувьд хүргэх, мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг татан ажиллуулах ажлыг зохион байгуулах, хөрш орнуудад сургаж бэлтгэх	НБХ,БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Боловсролын байгууллага мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан байна.
5	Багш, удирдах ажилтны сургалтын хэрэгцээг жил бүр тодорхойлон, судалгааны дагуу сургалтад хамруулах	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Багш, удирдах ажилтан бүр 100 хувь сургалтанд хамрагдсан байна.
6	Сургууль, багш, БСУГазар харилцан зөвшилцсөний үндсэн дээр сургуулийн удирдлага, багш нарыг солилцох, сэлгэн ажиллуулах, хөрш болон бусад орнуудын сургуулиудтай багш солилцох ажлыг зохион байгуулах	НБХ,БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Сургуулийн удирдлага, багш нарыг солилцох, сэлгэн ажиллуулах журам боловсруулж хэрэгжүүлсэн байна.
<b>1.1.2. Бүх шатны боловсролын сургалтын чанар, үр дүнг нэмэгдүүлж багш, сурагчдын олимпиад, уралдаан, тэмцээн, сурлагын чанар, амжилтыг нэмэгдүүлнэ.</b>					
1	Сургалтын чанар, үр дүнг сайжруулах “Амжилтын галт тэрэг” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, Бага боловсролыг хөгжүүлэх “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	НБХ,БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Суралцагчдын сурлагын амжилт, чанар нэмэгдсэн, хүүхэд багаасаа сурах арга барил эзэмшсэн байна.
2	Масс сургалтыг сайжруулах аймгийн чиглэлийг боловсруулж, амжилт гаргасан сургууль, багш нарыг урамшуулах	НБХ,БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Амжилт гаргасан багш нарыг урамшуулах журам боловсруулж хэрэгжүүлсэн байна.
3	Сургууль, цэцэрлэг бүрт хүүхдийн хөгжлийн танхим ажиллуулах, хүүхэд багачуудын авьяас чадвар, бие бялдар, урлаг гоо зүйн мэдрэмж, техник сэтгэлгээг нээн хөгжүүлэх хичээлээс гадуурх сургалт, дугуйлан, секцийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулах	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн 80-аас дээш хувь нь дугуйлан, секцийн үйл ажиллагаанд хамрагдсан байна.
4	Улсын “Математикийн Олимпиад”-ыг Булган аймагт зохион байгуулах бэлтгэл ажлыг	БСУГ, СЗДТГ, Сургууль,	2017	Улс, ОНТөсөв,	Математик сургалтын чанар нэмэгдэж, мэргэжлийн багш

	хангаж, чанартай зохион байгуулах	цэцэрлэг			нарын заах арга ур чадвар сайжирсан байна.
5	Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг, сургалтын төв байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын оролцоо дээшилсэн хамтын ажиллагааны түвшиг ахисан байна.
6	Аймгийн тэргүүлэх чиглэлийн судлагдахууныг тодорхойлж, орон нутгийн онцлогт тохирсон хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, Орон нутгийн сурах бичиг бэлтгэх	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв,	Математик, Гадаад хэл, Монгол хэл, Монгол бичиг, Байгалийн ухааны чиглэлийн хичээл тус бүрээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн байна.
<b>1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг бүх шатны боловсролд хамруулах, насан туршийн боловсролын бүтэц, үйл ажиллагааг шинэчилж, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.</b>					
1	Сургууль, цэцэрлэгийн гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, бүх шатны боловсролд хамруулах талаар дэмжлэг үзүүлэх	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Судалгаанд байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд бүрэн хамруулсан байна.
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэх	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020		Сум тус бүрээс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэнэ.
3	Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг өргөтгөх, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт зохион байгуулах	НБХ,БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020		БСУГ-ыг түшиглэн Насан туршийн боловсролын төвийг байгуулж сум бүрт “Гэгээрэл төв” ажиллаж үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.
<b>1.1.4. Сургууль, цэцэрлэгийн гадна, дотно сургалтын орчныг тохижуулах, хүүхдэд ээлтэй сурах орчин бүрдүүлэх, сургууль, цэцэрлэгийг интернэтэд бүрэн холбох, “Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</b>					
1	Хүүхдийн бие бялдар, оюун ухааныг хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр сургууль, цэцэрлэгүүдийг үе шаттайгаар хангах	НБХ,БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургууль, цэцэрлэгийн 70,0 хүртэлх хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангана.
2	Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны амьдрах нөхцлийг сайжруулах, халуун устай болгох	НБХ,БСУГ, СЗДТГ, Сургууль	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг ээлж дараагаар шийдвэрлэсэн байна.
3	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хэрэглэгдэхүүн, багш сурагчдын бүтээл, шилдэг тэргүүний арга туршлагыг багтаасан	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургууль тус бүр багш сурагчдын бүтээл, шилдэг тэргүүний арга туршлагыг багтаасан нэгдсэн

	нэгдсэн цахим сан бий болгох				цахим сантай болсон байна.
4	Бүх сумдын сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернэтэд холбох, сургуулийн дотуур байруудыг камержуулах багш нарыг цахим сургалтын арга зүйд сургах	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернэтэд бүрэн холбосон байна.
<b>1.1.5. Боловсролын салбарын байгууллагуудын барилгын өргөтгөл барих, их засвар хийх, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг тоглоомжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.</b>					
1	Бүрэгхангай, Гурванбулаг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Тэшиг сумдын болон Булган сумын 3-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийгдэж барилга ашиглалтанд орсон байна.
2	Хутаг-Өндөр сумын сургуулийн барилгын өргөтгөл барих	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургуулийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийгдэж барилга ээлж дараалалтайгаар ашиглалтанд орсон байна.
3	Дашинчилэн, Рашаант сумдын сургуульд тус бүр 100 хүүхдийн ортой дотуур байр шинээр барих, Бугат сумын сургуулийн барилга шинээр барих, Хялганат тосгоны сургуулийн дотуур байранд өргөтгөл хийх	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургуулийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийгдэж барилга ээлж дараалалтайгаар ашиглалтанд орсон байна.
4	Сайхан, Хишиг-Өндөр, Сэлэнгэ сумдын сургуулийн хичээлийн, Гурванбулаг сумын 320 хүүхдийн хичээлийн хуучин байранд их засвар хийх	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургуулийн барилгын засварын ажлыг хийж ашиглалтанд орсон байна
5	Бугат, Дашинчилэн, Рашаант, Хишиг-Өндөр, сумдын болон Булган сумын 1-р багийн цэцэрлэгийн сүрлэн барилга, 4, 6-р цэцэрлэгийн барилгад их засвар, Могод, Сайхан сумын цэцэрлэгийн барилгын суурийн болон сантехникийн засвар хийх	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийж ашиглалтанд орсон байна.
6	Гурванбулаг, Сайхан, Хишиг-Өндөр сумдын сургуулийн дотуур байранд их засвар хийх	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр	Сургуулийн дотуур байранд их засвар хийж ашиглалтанд орсон байна.
7	Тэшиг, Хишиг-Өндөр сумдын сургуульд спорт заал шинээр барих, Орхон сумын сургуулийн	БСУГ, СЗДТГ, Сургууль,	2016-2020	Улс, ОНТөсөв,	Сургуулийн спорт заал шинээр барьж ашиглалтанд орсон

	спорт заалыг засварлах	цэцэрлэг		төсөл, хөтөлбөр	байна.
8	Цэцэрлэгийн бүлгүүдийн хатуу, зөөлөн эдлэл, тоглоомыг ээлж дараалан шинэчлэх	БСУГ, СЗДТГ, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр иргэдийн оролцоо	Хатуу зөөлөн эдлэл, тоглоом 80 хувийг шинэчилсэн байна.
9	Дотуур байрны хатуу, зөөлөн эдлэлийг ээлж дараалан шинэчлэх	БСУГ, СЗДТГ, цэцэрлэг	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр иргэдийн оролцоо	Хатуу зөөлөн эдлэл 80 хувийг шинэчилсэн байна.

## 1.2 Эрүүл мэнд:

**Эрүүл мэндийн салбарын удирдлага, менежментийг сайжруулан, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг нотолгоонд суурилсан, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөн шинэчилж, материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэн залгамж халааг бэлтгэн, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэн, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгож, иргэдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжигч аюулгүй орчин бүрдүүлнэ.**

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Хүрэх үр дүн
<b>1.2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тандан судалж, хяналтын тогтолцоог сайжруулан, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулан, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ.</b>					
1	“Булган-Эрүүл мэндийн боловсрол хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцох	ЭМГ	2016-2020	ОНТөсөв	Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг тогтоосон суурь судалгаатай болно. Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшин 15%-иар нэмэгдэж, амьдралын зөв дадалтай хэвшилтэй болно.
2	Халдварт бус өвчний эрт илрүүлэгийн үзлэгийг багийн түвшинд зохион байгуулах ажлыг эрчимжүүлэн, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах	ЭМГ, ЭМБ-ууд	2016-2020	Улс, ОНТөсөв	Хорт хавдрын эрт илрүүлгийн тогтолцоо сайжирна. Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын түвшин 15%-иар нэмэгдэнэ.
3	“Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үндэсний стратеги”-ийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах	ЭМГ, ЭМБ-ууд	2016-2018	ОНТөсөв	Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратегийн хэрэгжилт сайжирна. Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг 20%-д хүргэж, эрт үедээ илэрсэн хавдрын

					илрүүлэлт нэмэгдсэн байна.
4	Хүн амын дунд амны хөндийн өвчлөлийг бууруулах ажлыг шат дараатай зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх	ЭМГ, ЭМБ-ууд, төрийн болон ТББ	2016-2020	ОНТөсөв	Хүүхэд, залуучуудын нөхөн үржихүйн болон амны хөндийн өвчлөлийг жилд 5%-аар бууруулах
5	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, эрүүл мэндийг дэмжигч төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	АЗДТГ, ЭМГ	2017-2020	ОНТөсөв	Эрүүл мэндийг дэмжигч сум, баг, байгууллага, өрх гэр бүлийн тоог 2 дахин нэмэгдүүлнэ. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа орон нутгийн түвшинд өргөжинө.
<b>1.2.2 Халдварт өвчний тандалт сэргийлэлт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулна.</b>					
1	Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, өвчлөлийн түвшинг бууруулах, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМГ, АНЭ	2016-2020	ОНТөсөв болон гадаадын хандив, тусламж	Эрт илрүүлэгийн хамрагдалт 85%-д хүрнэ. Эдгэрэлтийн түвшин 87%-д хүрнэ
2	Хүн амын дунд өндөр эрсдэлтэй байгаа БЗДХ өвчин нэн ялангуяа тэмбүү өвчнийг бууруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, хавьтал судлалыг эрчимжүүлэн, эмчилгээний үр дүнг тооцох	ЭМГ	2017-2020	ОНТөсөв	Зорилтот бүлгийн иргэдийн хамрагдалтыг 20%-д хүргэнэ БЗДХ, тэмбүү өвчний эрт үедээ оношлогдсон тохиолдлын тоо нэмэгдэнэ.
3	“Нэг дэлхий-Нэг эрүүл мэнд” зарчмыг хэрэгжүүлэн, дамжуулагчаар дамжих халдварт өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг сайжруулахад салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн, өвчлөлийн талаарх эргэн мэдээллийн тогтолцоог нэмэгдүүлэх	АЗДТГ, ЭМГ	2017-2020	ОНТөсөв	Зоонозын халдварт өвчний талаар салбар дундын хамтын ажиллагаа өргөжиж, бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхи сайжирна. Сум бүрт салбар дундын баг байгуулагдана. Нөөц хангамжийг 10%-иар нэмэгдүүлнэ.
4	Гамшиг, гэнэтийн аюул, осол, олон нийтийг хамарсан хүний эрүүл мэндэд онц аюул учруулах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний бэлэн байдал, нөөц хангамжийг сайжруулахад төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах	АЗДТГ, ЭМГ, ОБГ, ХХААГ	2017-2020	ОНТөсөв	Гамшигийн үед үзүүлэх тусламж үйлчилгээний бэлэн байдал, нөөц хангамжийг 10%-иар нэмэгдүүлнэ
5	Эрүүл мэндийн байгууллагуудын “Дархлаажуулалтын кабинет”-ийн үйл	ЭМГ	2017-2018	Улс, ОНТөсөв	Дархлаажуулалтанд хамрагдсан иргэдийн дархлалын түвшин

	ажиллагаа болон заавал хийх дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн дархлалын түвшинг үнэлж, дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах				тогтоогдоно.Судалгааны үр дүнд үндэслэн цаашид авах арга хэмжээг тодорхойлно ЭМБ-уудын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна.
<b>1.2.3 Өрх, сум, багийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт болон уламжлалт анагаах ухааны аргыг хослуулан, тоног төхөөрөмжийг сайжруулна.</b>					
1	“Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМГ	2017-2020	Улс, ОНТөсөв	Эрүүл мэндийн салбарт баримтлан ажиллах бодлогын баримт бичгийг хэрэгжилт эрчимжин, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, тэгш байдал сайжирна.
2	Сум, багийн түвшинд “Аймгийн Засаг даргын нэрэмжит” нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулан, иргэдийн дунд зонхилон тохиолдож буй өвчлөлүүдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, эмчилгээний үр дүнг тооцон, иргэдийг мэдээлэлээр хангах	АЗДТГ, ЭМГ, АНЭ	2017-2020	ОНТөсөв	Нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна Орон нутгийн хүн амын 20% хамрагдана Иргэдийн өвчлөлийг эрт илрүүлж, хүндрэлээс урьдчилан сэргийлнэ. Эмчлэн эрүүлжүүлэх ажил эрчимжинэ.
3	Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад уламжлалт анагаах ухааныг түгээн дэлгэрүүлж, мэргэжилтнүүдээр ханган, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д	2016-2020	ОНТөсөв	Эмийн бус эмчилгээний чанар сайжирна. Эмийн эмчилгээний зардал хэмнэгдэнэ.
4	Сумдын Эрүүл мэндийн байгууллагуудын “Яаралтай тусламж”-ийн хэсгийг стандартын шаардлагад нийцүүлэн цогц байдлаар үе шаттайгаар зохион байгуулж, эрсдлийн түвшинг бууруулах	НХХ, ЭМГ, АНЭ	2016-2020	Улс, ОНТөсөв	Яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдана. Иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.
<b>1.2.4 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэдэд сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.</b>					
1	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн стандартын түвшинд мэргэжлийн байгууллагатай хамтран үнэлгээ хийж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эмч, эмнэлгийн мэргэжилтнээр	ЭМЯ, ЭМГ	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.

	шат дараатай хангах ажлыг зохион байгуулан, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх				
2	“Яаралтай тусламжийн тасаг”-ийг стандартын түвшинд нийцүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх	НХХ, ЭМГ, АНЭ	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдана.Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдэнэ.
3	“Гемодиализын эмчилгээ”-г нэвтрүүлэн, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг сайжруулах	НХХ, ЭМГ, АНЭ	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Орон нутагт бөөр орлуулах эмчилгээг хийх нөхцөл бүрдэж, иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.
4	“Дурангийн кабинет”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, Гэмтэл, мэс заслын тусламж үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх	НХХ, ЭМГ, АНЭ	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээний чанар сайжирна. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдэнэ.
5	“Эх, хүүхдийн эрүүл мэнд стратеги”-ийг хэрэгжүүлж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах	ЭМГ, АНЭ, Өрхийн ЭМТөв	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Стратеги 90%-аас дээш хэрэгжсэн байна. Нөхөн үржихүйн насны иргэдийг 90% хамруулсан байна.
6	Эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайны оношилгоог нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	НХХ, ЭМГ, АНЭ	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ.
7	“Эрүүл насжилт-настны эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	НХХ, ЭМГ, АНЭ	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна. Насжилтыг уртасгаж, настны амьдралын чанарыг өөрчлөх
8	Аймгийн Нэгдсэн эмнэлгийг түшиглэн “Эмчилгээний хоолны газар”-ыг стандартад нийцүүлэн байгуулж, сумдын Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах	ЭМГ, АНЭ	2017-2020	ОНХС 136 сая төгрөг	Эмчилгээний хоол үйлдвэрлэлийн стандарт хангагдана.
9	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Уламжлалт анагаах ухааны төв” байгуулж, уламжлалт	Улсын болон хувийн хэвшлийн	2016-2020	Улсын төсөв ОНХС, Хандив	Эмнэлгийн эмийн эмчилгээний зардал буурч, эмийн зохистой



	болон сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэх	ЭМБ-д		тусламж	хэрэглээ төлөвшинө Нөхөн сэргээх эмчилгээний үр дүн сайжирна.
10	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет”-ийг байгуулж, эрчүүдийн дунд тохиолдож буй өвчлөл, эндэгдлийг бууруулах	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д	2016-2020	Улсын төсөв ОНХС, Хандив тусламж	Эрэгтэйчүүдийн дундах өвчлөлийг бууруулна.
<b>1.2.5 Сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагаанд орчин үеийн шинэлэг аргуудыг нэвтрүүлнэ.</b>					
1	Эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн тусламж үйлчилгээнд мэргэжлийн байгууллагын үнэлгээ хийж, сувилгаа асаргааны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д	2016-2018	Улс, ОНТөсөв хандив тусламж	Шинэ технологийг нэвтрүүлж, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдэнэ.
2	Эрүүл мэндийн байгууллагуудад “Туслах сувилагч”-ийг бэлтгэн ажиллуулж, сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх, сэргээн засах, уламжлалт сувилгааг өргөжүүлэх	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д	2016-2018	Улс, ОНТөсөв хандив тусламж	Нэг сувилагчид ноогдох өвчтөний тоо цөөрнө Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж дээшилнэ. Хөнгөвчлөх эмчилгээний чанар сайжирна.
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Өдрийн эмчилгээний төв”-ийг байгуулан, урьдчилан сэргийлэх асаргаа, сувилгаа, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг өргөжүүлэх	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д	2016-2020	Улс, ОНТөсөв хандив тусламж	Гэрээр үзүүлэх асаргаа сувилгааны чанар сайжирна. Хүнд, хэвтрийн өвчтний ар гэрийн, асран хамгаалагч нарын эрүүл мэндийн мэдлэг нэмэгдэнэ.
<b>1.2.6 Эм зүйн шинжлэх ухааны шинэ аргуудыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны эмчилгээнд нэвтрүүлнэ.</b>					
1	Эрүүл мэндийн байгууллагуудад эм зүйн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөн, эм зүйн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	ЭМГ, ЭМБ, ЭХБ	2016-2020	Улсын төсөв	Эрүүл мэндийн байгууллагуудын зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь нэмэгдэнэ.
2	Эм зүйн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, “Уламжлалт анагаах ухааны эмчилгээний эмийн сан”-г шинээр байгуулах	ЭМГ, ЭМБ, ЭХБ	2016-2020	Улсын төсөв	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг уламжлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах 1 эмийн санд олгосон байна.
<b>1.2.7 Иргэдийн эрүүл мэнд, амь насыг аврагч, хүмүүнлэг сэтгэлтэй сайн дураараа цусаа хандивлагч донорын эгнээг өргөтгөн, сайн үйлсийг нь сурталчлан, тэдний эгнээнд иргэдийг өргөнөөр татан оролцуулна.</b>					

1	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт стандартын шаардлага хангасан “Цусны төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах	ЭМГ, АНЭ	2016-2020	Улсын төсөв, ОНХС	Цус, цусан бүтээгдэхүүний хангамж сайжирч, аюулгүй бэлэн байдал сайжирна.
2	Залуучууд, өсвөр үеийнхний дунд Донорын эгнээг өргөтгөн, сайн үйлсийг нь сурталчлан, Донорын тоог нэмэгдүүлэх	АЗДТГ, ЭМГ АНЭ,	2017-2020	Улс, орон нутгийн төсөв	Сайн дураараа цусаа бэлэглэх өр авлагагүй донорын тоо нэмэгдэнэ Аймгийн хэмжээний цусны яаралтай бэлэн байдлын нөөц бүрдэнэ
<b>1.2.8 Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах хүний нөөцийн хөгжлийн аймгийн бодлогыг тодорхойлж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэн, залгамж халааг бэлтгэнэ.</b>					
1	“Булган аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого”-ыг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцох	АЗДТГ, ЭМГ Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	2017-2020	Улс, ОНТөсөв	Бодлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулсан байна Хөтөлбөрийн хэрэгжилтийг 90-с доошгүй хувьд хүргэнэ.
2	Эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	АЗДТГ, ЭМГ	2017-2020	Улс, ОНТөсөв	Жилд 1-ээс доошгүй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагажуулна
3	Эрүүл мэндийн салбарын “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцох	АЗДТГ, ЭМГ Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	2017-2020	Улс, ОНТөсөв	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 90-с доошгүй хувьд хүргэнэ.
<b>1.2.9 Эрүүл мэндийн байгууллагуудын орчин нөхцлийг сайжруулан, мэдээллийн технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.</b>					
1	Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжид мэргэжлийн байгууллагуудтай хамтран үнэлгээ хийж, шинээр барих, их засвар болон урсгал засварыг салбар дундын хамтын ажиллагаатайгаар хийж, иргэдэд ээлтэй эрүүл мэндийн орчин бүрдүүлэх	АЗДТГ, ЭМГ	2016-2020	Улсын төсөв 2.4 тэрбум төгрөг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
2	Булган суманд 30 ортой халдварт сүрьеэгийн эмнэлэг шинээр барих	АЗДТГ, ГХБХБГ	2016-2020	Улсын төсөв	Төрөлжсөн эмнэлгийн тусламжийн орчин бүрдэнэ.
3	Эрүүл мэндийн байгууллагуудыг стандартын шаардлагад нийцсэн орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх	АЗДТГ, ЭМГ	2017-2020	Улсын төсөв, ОНХС	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна

4	Аймгийн нэгдсэн эмнэлгийн болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлтийг үе шаттай хийх	АЗДТГ, ЭМГ	2017-2020	Улсын төсөв, ОНХС 217 сая төгрөг	Яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдал хангагдана.
---	---	------------	-----------	-------------------------------------	--

### 1.3 Нийтийн биеийн тамир, спорт

**Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэлгэрүүлж, спортыг бүх нийтийн үйл хэрэг болгож, эрүүл, аз жаргалтай амьдралыг цогцлоон бүтээнэ.**

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Хөрөнгийн үүсвэр	Хүрэх үр дүн
<b>1.3.1. Тамирчдын хөгжих, уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэхэд анхаарч, амжилт гаргах, алдаршуулахад бодлогоор дэмжиж ажиллана.</b>					
1	Тамирчдын уралдаан тэмцээн, шагнал урамшуулалд дэмжлэг үзүүлэх зорилгоор сан байгуулах, түүний эрх зүйн орчинг бүрдүүлэх	АЗДТГ,НБХ БТСГ, СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв, төсөл, хөтөлбөр Хандив, тусламж	Тамирчид багш дасгалжуулагчдын идэвх санаачлага дээшилж, амжилтын тоо ахисан байна
2	“Монгол улсын Биеийн тамир, спортын тухай хууль”-ийн дагуу Хүүхдийн, Ахмадын, Үндэсний спортын, Бүх ард түмний спортын наадмуудыг зохион байгуулах, улсын тэмцээнд тамирчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх	АЗДТГ,НБХ БТСГ СЗДТГ	2016-2020	Улс, ОНХС Спорт холбоодын хөрөнгө оруулалт	Хүмүүсийн оролцоо нэмэгдэж амжилт сайжирсан байна
3	Үндэсний бөх, сур, шагайн спортыг бодлогоор дэмжиж улсын алдар цолтой хүмүүсийн нэрэмжит тэмцээнийг уламжлал болгон тогтмолжуулах, сурталчлах ажлыг үе шаттайгаар хийх	АЗДТГ,НБХ БТСГ Спортын холбоод	2016-2020	Орон нутгийн төсөв, хөтөлбөр, Спорт холбоодын хөрөнгө оруулалт	Алдартнуудаа сурталчилж үндэсний спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна
4	Үндэсний уламжлал соёл, ёс заншил, өв уламжлалаа тээж яваа уяачид хурдан морь сонирхогчид, малчидтай хамтран ажиллаж үйл ажиллагааг нь дэмжиж, уралдаанч хүүхдүүдийн эрхийн талаар хамтран ажиллах	АЗДТГ,НБХ БТСГ,МСУХ ХГБХХ	2016-2020	Орон нутгийн төсөв, хөтөлбөр, спорт холбоодын хөрөнгө оруулалт	Үндэсний спорт, уламжлал сэргэж, уралдаанч хүүхдүүдийн эрхийг хамгаалах ажил зохих түвшинд дээшилсэн байна.
	Ерөнхий боловсролын сургуулиудад Олимпийн сургалт, сурталчилгааны	АЗДТГ,НБХ БТСГ, ЕБС	2016-2020	МҮОХорооны төсөл, хөтөлбөр	Хүүхдүүдийн спорт олимпизмийн мэдлэг, зохих түвшинд

5	танхимуудыг байгуулан үзүүлэн таниулах материалаар үе шаттай хангах	“Москва” олимпийн зөвлөл			дээшилсэн байна.
<b>1.3.2.Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлнэ.</b>					
1	Аймаг сумын төвүүдийн гудамж, нийтийн эзэмшлийн талбайд ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудад зориулсан ногоон байгуулж бүхий гүйлт, дугуйн зам, спорт тоглоом, мөсөн гулгуурын талбай байгуулах ажлыг эхлүүлэх	АЗДТГ,НБХ, Булган СЗДТГ ГХБХБГ БТСГ	2016-2020	ОНХС	Ард иргэдийн нийтийн биеийн тамираар чөлөөтэй хичээллэх боломж бүрдсэн байна.
2	Хүн амыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, эрүүл амьдралын дадал, хэвшилд сургах чиглэл бүхий нийтийн биеийн тамирын сайн дурын танхим, клуб, хамтлагуудыг дэмжиж ажиллах	АЗДТГ,НБХ БТСГ Агентлагийн удирдлага СЗДТГ	2016-2020	Улс, ОНХС	Албан байгууллагын ажиллагсдын идэвх санаачлага нэмэгдэж эрүүл амьдралын дадал, хэв маяг хэвшсэн байна.
<b>1.3.3. Спортын тодорхой төрлүүдийг /үндэсний сур, цана, тэшүүр, бөхийн төрлүүд, волейбол, хөнгөн атлетик, волейбол, бокс, буудлага, таеквандо, хөнгөн атлетик, сагсан бөмбөг г.м/ түлхүү хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.</b>					
1	Үндэсний наадгай сур харвааг хөгжүүлэх зорилгоор “Монгол нум сум” хөтөлбөр хэрэгжүүлэх	АЗДТГ, НБХ БТСГ, БСУГ	2016-2020	Аймаг орон нутгийн төсөв	Эрийн гурван наадмын нэг үндэсний наадгай сур харвааг хөгжүүлж хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна
2	Шагай харвааг хөгжүүлэхийн зэрэгцээ түгээн дэлгэрүүлэх холбоо, багуудыг дэмжиж ажиллах	АЗДТГ, НБХ БТСГ, БСУГ	2016-2020	Аймаг, орон нутгийн төсөв	Шагай харвааг хөгжүүлж, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж Хангинахын шугуйн шагайн тойрмын хамрах хүрээг тэлж улмаар жуулчдын анхаарлыг татсан эвент арга хэмжээ болгосон байна
3	Цана, тэшүүр, бөхийн төрлүүд самбо, жудо, чөлөөт, үндэсний бөх зэрэг волейбол, сагсан бөмбөг, бокс, буудлага, хөнгөн атлетик, таеквандо, ширээний теннис зэрэг спортыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулах	АЗДТГ, НБХ БТСГ Спортын холбоод	2016-2020	Орон нутгийн төсөв хөтөлбөр	Орон нутгийн брэнд төрлүүд болон хөгжсөн байна
4	“Шатар” хөтөлбөрийг үргэлжлүүлж, оюуны спортыг хөгжүүлэх	АЗДТГ,НБХ БТСГ	2016-2020	Орон нутгийн төсөв, хөтөлбөр	Шатрын спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдэж, улс аймгийн тэмцээн уралдаанд үзүүлэх амжилт ахисан байна.
<b>1.3.4. Спортын салбарын материаллаг баазыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.</b>					
1	Спортын шинэ ордны дээвэр, халаалт иж бүрэн засварыг хийж гүйцэтгэх	БСШУСЯ АЗДТГ, НБХ	2016-2020	Авзага трейд ХХК санхүүжилтээр	Улсын комисс хүлээн авсан акт гаргуулсан байна.

		БТСГ			
2	Хялганат тосгоны спорт заалыг ашиглалтад оруулж үйл ажиллагааг хэвийн явуулах боломжоор хангах	АЗДТГ, НБХ СЗДТГ	2016-2020	Улс,ОНХС	Хялганат тосгоны ард иргэд нийтийн биеийн тамираар хичээллэх таатай орчин нөхцөлтэй болсон байна.
3	Б заалны их засвар	АЗДТГ, НБХ СЗДТ	2016-2020	ОНХС	Орчин, нөхцөл сайжирсан байна.
4	Спортын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх	АЗДТГ, НБХ СЗДТ	2016-2020	Улс, ОНХС-жилд 10 сая төгрөг	Спортын секцүүдийн үйл ажиллагаа сайжирч, хичээллэгсэдийн тоо өсч, спортод гаргах амжилт ахисан байна.

#### 1.4 Соёл, урлаг

**Үндэсний өв уламжлал, орчин үеийн дэвшилтэт соёлыг шингээсэн иргэдийг төлөвшүүлэн урлаг гоо зүйн боловсролыг дээшлүүлж, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин өргөжүүлэх замаар аймаг сум, багийн түвшинд “Соёлын довтолгоон”-ийг эхлүүлнэ.**

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Хүрэх үр дүн
<b>1.4.1. Соёл урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соёлын үйлчилгээг шинэ шатанд гаргаж, Соёл урлагийн ажилтнуудыг сургах, давтан сургах ажлыг ээлж дараатай зохион байгуулах, мэргэжлийн урлагийн байгууллагуудын мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлнэ.</b>					
1	Соёл, урлагийг хөгжүүлэх зорилгоор аймгийн “Соёл урлагийн бодлого”-ыг боловсруулж, хэрэгжүүлэх	АЗДТГ, НБХ, БСУГ	2016-2020	Орон нутгийн төсөв	Соёл урлагийн бодлого хэрэгжиж орон нутгийн түвшинд соёлын чиг хандлага тодорхойлогдож, соёл урлагийн үйлчилгээ шинэ шатанд хүрсэн байна
2	Сумдын соёл, урлагийн өдрүүдийг тогтмол зохион байгуулахын зэрэгцээ урлаг соёлын үйлчилгээ үзүүлж, эд өлгийн зүйл, сум орон нутгийн онцлогийг харуулсан үзэсгэлэн гаргах	АЗДТГ, НБХ, БСУГ Сумдын ЗДТГ	2016-2020	Орон нутгийн төсөв	Сум, орон нутгийн бусдаасаа ялгарах онцлогийг харуулж, орон нутгаа сурталчлах, сумдын соёлын брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлно.
3	Аймгийн “Ардын урлагийн наадам”-ыг 2 жилд 1 удаа зохион байгуулж, тэргүүн байруудын уран бүтээлчдийн бүтээлийг олон нийтэд	АЗДТГ,НБХ, БСУГ	2016-2020	Орон нутгийн төсөв, Орон нутгийн	Булган нутгийн уран бүтээлчдийн бүтээл олон нийтэд тодорхой түвшинд танигдсан байна

	сурталчилж, авьяас билигтнүүдээ алдаршуулах			хөгжлийн сан	
4	Булган сумын Соёлын ордны бүтэц, орон тоог нэмэгдүүлж, стандартын дагуу ажиллуулах, ЕБС-ийн сургуулийг түшиглэн “Гитар” хөтөлбөр хэрэгжүүлж, сум, сургууль бүр хөгжмийн хамтлагтай болох	АЗДТГ, НБХ, БСУГ Булган, СЗДТГ Булган сумын соёлын ордон	2016-2020		Булган сумын соёлын ордны үйлчилгээ чанаржиж үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.
5	Гадаад орны элчин сайдын яамдтай хамтран тухайн орны урлаг, соёлын өдрүүд, кино өдрүүд зохион байгуулах	АЗДТГ, НБХ, БСУГ Булган, СЗДТГ Булган сумын соёлын ордон	2016-2020		Соёлын үйлчилгээний төрөл, чанар нэмэгдэнэ.
<b>1.4.2. Соёлын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулах, зарим сумдын “Соёлын төв”-үүдийг шинээр барих, их засвар хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шат дараатай нэмэгдүүлнэ.</b>					
1	ХЖТ, Аймгийн Төв номын сан, Бугат сум, Хялганат тосгоны соёлын төвийн шинэ барилгын асуудлыг шийдвэрлэх /орчин үеийн стандартад нийцсэн барилгатай болгох/	АЗДТГ, НБХ БСУГ	2016-2020	Улс, ОНТөсөв	Аймгийн Хөгжимт жүжгийн театр орчин үеийн стандартад нийцсэн барилгатай болж үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, үйлчилгээнд чанарын ахиц гарсан байна.
2	Аймгийн музейн барилгын өргөтгөл, шинэчлэл, Баруун замын тусгай ангийн штаб-музейн барилга, Ардын Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхныг засварлаж тохижуулах	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн музей	2016-2020	Улс, ОНТөсөв	Музейн үйл ажиллагаа явуулахад таатай орчин бүрдэж үйлчлүүлэгчдийн тоо эрс нэмэгдсэн байна.
3	Баяннуур сумын “Шороон бумбагар”-т музей байгуулах, зарим олдворыг аймгийн музейн сан хөмрөгт татан байрлуулах	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн музей	2016-2020	Улс, ОНТөсөв	Музей байгуулснаар аялал жуулчлал хөгжих нэг нөхцөл бүрдэж, аймгийн музейн үзвэр баяжсан байна.
4	Баяннуур, Могод, Гурванбулаг, Хангал сумдын соёлын төвийн их засвар	АЗДТГ, НБХ БСУГ	2016-2020	Улс, ОНТөсөв	Соёл урлагийн үйлчилгээг таатай орчинд хүргэж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна
5	ХЖТ, Номын сан, Соёлын төвүүдийг камержуулах	АЗДТГ, НБХ БСУГ АТНС	2016-2020	Улс, ОНТөсөв	Аюулгүй орчинг бүрдүүлсэн байна.
6	Хялганат тосгон, Орхон сумдын соёлын төвийн гэрэлтүүлэг, хөгжим техник хэрэгсэл, Хутаг-Өндөр сумын соёлын төвийг хөгжим, техник хэрэгсэл болон үзэгчдийн сандлын тоог нэмэгдүүлэх, Бугат сумын соёлын төвийг	АЗДТГ, НБХ БСУГ СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв	Сумдын соёл урлагийн үйлчилгээ чанаржиж үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.

	цахилгаан хөгжмийн зэмсгээр хангах				
7	Сумын номын сангуудад интернэт үйлчилгээг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	АЗДТГ, НБХ БСУГ СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв	Үйлчилгээний таатай орчин бүрдсэн байна.
<b>1.4.3. Гадаад харилцааг өргөжүүлж, үндэсний соёл урлагийг сурталчилж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.</b>					
1	ОХУ-ын Буриад улс, Красноярскийн хязгаар, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны музейнүүдтэй хамтран ажиллах, харилцаа холбоо тогтоох, аймаг, орон нутгаа сурталчилсан нүүдлийн музей, үзэсгэлэн ажиллуулах	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн музей	2016-2020	ОНТөсөв,	ОХУ-ын Буриад, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орнуудад аймаг орон нутгаа сурталчилж хамтын ажиллагаа өргөжсөн байна.
2	ОХУ-ын Буриад улсад хоёр улсын гэрээгээр суралцаж байгаа оюутнуудыг боловсролын хамтын ажиллагааны байгууллагуудын тэтгэлэгт хамрагдахад дэмжлэг үзүүлэх	АЗДТГ, НБХ БСУГ	2016-2020	ОНТөсөв,	ОХУ-ын Буриад улсад суралцаж байгаа оюутнууд тэтгэлэгт хамрагдаж эхэлснээр оюутнуудын тоо нэмэгдсэн байна.
3	Хөрш зэргэлдээх орнуудын соёлын байгууллагуудтай хамтран ажиллаж Соёлын ордны дэргэдэх дугуйлангийн хүүхдүүдийг хамруулсан Соёлын өдрүүд арга хэмжээг зохион байгуулах	АЗДТГ, НБХ БСУГ	2016-2020	ОНТөсөв,	Хөрш орнуудын соёл урлагийн байгууллагуудтай хамтран ажиллаж соёл урлагийн олон талт ажлыг зохион байгуулж орон нутгаа сурталчилсан байна.
4	Аймгийн нутаг дэвсгэрт оршдог улс, аймгийн хамгаалалттай 36 дурсгалыг гадаад, дотоодод сурталчилсан ном, товхимол, газрын зураг, музейн танилцуулга /монгол, орос, англи, хятад хэлээр/ хэвлэж сурталчлан жуулчдын сонирхол татсан үйл ажиллагааг зохион байгуулах	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн Музей	2016-2020	ОНТөсөв,	Түүх соёлоо олон улсад сурталчлах таатай боломж бүрдсэн байна.
<b>1.4.4. Үндэсний уламжлал, өв соёлоо өвлүүлэх, хөгжүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.</b>					
1	“Монгол ардын уртын дуу” хөтөлбөрийг боловсруулж сум болгонд 9-өөс доошгүй дуучдыг бэлтгэх, “Уран нугаралт” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж шавь сургалтаар өвлөн авч явах боломжийг хангаж, өвийг бэхжүүлэх талаар дэмжлэг үзүүлэх	АЗДТГ, НБХ БСУГ СЗДТГ	2016-2020	ОНТөсөв,	“Монгол ардын уртын дуу” хөтөлбөр хэрэгжиж уртын дуу дуулаачдын тоо эрс нэмэгдсэн байна
2	“Морин хуур” хөтөлбөрийг үргэлжлүүлж, сургагч багш нарын урамшууллыг орон нутгийн төсөвт суулгаж, Морин хуур урлаачдыг бүсчлэн бэлтгэж, тогтвортой үйл	АЗДТГ, НБХ БСУГ СЗДТГ	2016-2020	ОНТөсөв,	Морин хуурчдын тоо жилээс жилд нэмэгдэж, мөн морин хуур урлаачдын бүтээл зах зээлийн эргэлтэд орж морин хуур

	ажиллагаатай болгох				худалдан авах хөрөнгө орон нутгийн төсөвт төвлөрөх болно. Хөтөлбөр амжилттай хэрэгжиж үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлсэн шилдэг аймаг болно.
<b>1.4.5. Музейн үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалын зүйлсийг хамгаалах, үзмэрийг гадаад, дотоодод сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулна.</b>					
1	Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт, тохижилтыг стандартын дагуу хийж гүйцэтгэн, байнгын арчилгаатай болгох	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн музей	2016-2020	ОНТөсөв,	Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт сайжирч устаж сүйдэх аюулгүй болсон байна.
2	Сумдын орон нутаг судлалын танхим, ЕБС-ийн түүхийн танхимын үзмэр, эд өлгийн зүйлийг тоолж баталгаажуулах	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн Музей	2016-2020	ОНТөсөв,	Нэгдсэн санд бүртгэсэн байна
3	Аймгийн 80-н жилийн ойн хүрээнд чихмэлүүдийг шинэчлэх, музейн үзмэр үзүүлэг, дэглэлтийг орчин үеийн стандартаар Үндэсний түүхийн музейн арга зүйн зөвлөлтэй хамтран хийх	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн Музей	2016-2020	ОНТөсөв,	Үзмэр эд өлгийн зүйл шинэчлэгдсэн байна.
4	Аймгийн түүх, соёл, уламжлалт ахуй, өвийг сурталчлан таниулах, нутаг, орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготой олон төрлийн арга хэмжээг сургууль, цэцэрлэг, аймгийн музейтэй хамтран зохион байгуулах	АЗДТГ, НБХ БСУГ Аймгийн Музей	2016-2020	ОНТөсөв,	Хүүхэд, сурагчдын түүх соёлын мэдлэг дээшилсэн байна.
<b>1.4.6. Номын фонд баяжилтыг нэмэгдүүлж, сумдын номын сангуудын орчин нөхцлийг сайжруулан үйл ажиллагааг өргөжүүлнэ.</b>					
1	Бүх нийтээр ном унших хөдөлгөөн өрнүүлэн, “Нүүдлийн номын сан”-гийн үйлчилгээг эрчимжүүлэх хөдөөгийн багт хувиараа номын сан байгуулах иргэдийг дэмжих	АЗДТГ, НБХ БСУГ АТНС	2016-2020	ОНТөсөв,	Ард иргэдийг номтой нөхөрлүүлэх ажил эрчимжиж ном уншигчдын тоо нэмэгдсэн байна.
2	Аймаг сумдын номын сангийн фонд баяжилтыг үе шаттайгаар хангах	АЗДТГ, НБХ БСУГ СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв,	Уншигчдын тоо болон номын фонд баяжилтыг нэмэгдүүлсэн байна.

#### 1.5 ХҮН АМ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ



**Хүн амын бодлогыг хүн амын төрөлтийг дэмжиж, нас баралтыг бууруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүн амыг тогтвортой ажлын байраар хангаж, орлогын байнгын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоход бодлого үйл ажиллагаагаа чиглүүлнэ.**

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Хөрөнгийн үүсвэр	эх	Хүрэх үр дүн
<b>1.5 Хүн амын хөдөлмөр эрхлэлт</b>						
<b>1.5.1 Аймгийн оюутан залуучууд, МСҮТ-үүдийг төгсөгчдийн нэгдсэн судалгааг гаргаж, аймгийн нийгэм, эдийн засгийн бодлоготой уялдуулан шинэ залуу боловсон хүчнийг дэмжих зорилгоор “Булгандаа ирлээ” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, төгсөгчдийг ажлын байраар хангасан хувийн хэвшлийн байгууллагуудыг дэмжин хамтран ажиллана.</b>						
1	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчийн болон МСҮТ-үүд, бусад их дээд сургууль төгсөгчдийн нарийвчилсан судалгааг гарган, нэгтгэн мэдээллийн сан үүсгэх	АЗДТГ, НБХ, ХХҮГ, БСУГ, СЗДТГ	2016-2020	-		Мэдээллийн сан үүсгэн салбар дундын хамтын ажиллагаанд ашигласан байна.
2	Шинэ залуу боловсон хүчнийг дэмжих зорилгоор “Булгандаа ирлээ” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	АЗДТГ, НБХ, ХХҮГ, БСУГ, СЗДТГ	2016-2020	Орон нутгийн хөгжлийн сан 100,0 сая		Хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж төгсөгчдийн 70-аас дээш хувийг ажлын байраар хангасан байна.
3	Ажилгүй болон эмзэг бүлгийн иргэдийн мэргэжил, ур чадвар, хүсэл сонирхлыг харгалзан, МСҮТ, бусад бизнесийн төвүүдтэй хамтран “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажиллах	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв		Ажил, мэргэжилгүй иргэдийн 80 гаруй хувийг тус хөтөлбөрт хамруулан төгсөгчдийн 50-аас дээш хувийг ажлын байраар хангасан байна.
4	МСҮТ-д суралцагсдын үйлдвэр дээрх дадлага хийх орчин нөхцлийг бүрдүүлэн, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, багш нарыг давтан сургах, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх зэрэг ажлыг зохион байгуулах	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв ХЭДС		Дадлага хийх орчин нөхцөлийг сайжруулж, 2 МСҮТ-ийн зарим техник тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна.
5	Их, дээд сургууль болон МСҮТ-үүдийг төгссөн шинэ залуу боловсон хүчний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, шинээр байнгын болон түр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжин, хамтран ажиллаж урамшуулал олгоно.	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв ХЭДС		Жилд 10-аас доошгүй ажил олгогчийг дэмжин урамшуулал олгосон байна. Төгсөгчдийн 70-аас доошгүй хувь нь ажлын байраар хангагдсан байна.
<b>1.5.2 Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо, нөхөрлөл, өрхийн болон фермерийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгон ажилгүйдлийг бууруулан иргэдийг тогтвортой ажлын байраар хангана.</b>						
1	Жил бүр 1500-аас доошгүй шинэ ажлын байр	ХХҮГ, МСҮТ,	2016-2020	Улс орон нутгийн		6000-аас доошгүй шинэ ажлын

	бий болгох	СЗДТГ		төсвөөс ХЭДС	байрыг бий болгож, хүн амын ажилгүйдлийг бууруулна.
2	Хөдөлмөр эрхлэх зорилго, чиглэл, ажлын дадлага, туршлагаар нь нэгтгэн хоршоо, нөхөрлөл, фермерийн аж ахуй эрхлэх, хуримтлалын бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлж, зээл олгох /үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарих, гахай тахиа үржүүлэх болон бусад чиглэлээр туслах аж ахуй/	ХХҮГ, ХХААГ СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	2016-2020	Улс, ОНТөсөв ХЭДС	Хоршоо, $i^o \delta^o \delta e^o \delta e$ , $\delta \delta i$ ерийн аж ахуй эрхлэх, хуримтлалын бүлгүүдийн тоо нэмэгдэж өрхийн амжиргаа, өрхийн орлого нэмэгдсэн байна.
3	Нийтийг хамарсан түр болон улирлын ажлын байраар хангах хөтөлбөрийг орон нутгийн нөөц бололцоо, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлж ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажиллуулж түр, улирлын ажлын байраар хангах	ХХҮГ, ХХААГ СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	2016-2020	Улс, ОНТөсөв	Ажилгүй иргэдийн 50-аас доошгүй хувийг нийтийг хамарсан ажилд оролцуулж өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна.
4	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх	ХХҮГ, ХХААГ СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	2016-2020	Улс, ОНТөсөв, ХЭДС	Жижиг бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэн инкубатор төвийн тоог нэмэгдүүлсэн байна.
5	Нийгмийн зорилтот бүлгийн иргэдийг ногоон ажлын байраар хангах ажлыг зохион байгуулж, байгаль орчны чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт хамруулах	ХХҮГ, ХХААГ, БОАЖГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	2016-2020	Улс, ОНТөсөв, Байгаль хамгаалах сан	Ойн нөхөрлөлийн тоо нэмэгдэж орлого багатай өрхийн гишүүд ногоон ажлын байраар хангагдсан байна.
6	Баг бүрт 1,0-2,0 сая төгрөгний “Бичил зээл”-ийн эргэлтийн санг нэмэгдүүлэх өрхийн бичил бизнесийг дэмжин зээл олгох, үр дүн тооцох	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	2016-2020	“Бичил зээл”-ийн $ud\ddot{a}y\ddot{e}\ddot{o}\ddot{e}\ddot{e}i \ddot{n}ai$ буюу ОНХС	Багийн иргэдийн амжиргаа дээшилж, өөрийн гэсэн эргэлтийн хөрөнгөтэй болсон байна.
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн дагуу урамшуулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тэдний хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, худалдан борлуулах цэгийг байгуулах	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	2016-2020	Улс орон нутгийн төсөв, ХЭДС,	ХБИ-ийн орлого нэмэгдэж тэдний 40-50 хувь нь ажлын байраар хангагдсан байна. Бүтээгдэхүүнийг худалдан борлуулах цэг бий болж, үйл ажиллагаа нь эрчимжсэн байна.
8	“40-өөс дээш болон ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг	ХХҮГ, СЗДТГ, ААХолбоо	2016-2020	Улс, ОНТөсөв, ХЭДС,	Хөдөлмөр эрхлэх чадвартай ахмад настнуудыг хамруулж 30-

	аймгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.				аас доошгүй хувийг түр ажлын байраар ханган өрхийн амжиргааг нь дэмжсэн байна.
9	Ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажлын байранд зуучлах, ажлын байрны мэдээллийг олон нийтэд хүргэх, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор "Хөдөлмөрийн яармаг"-ийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах	ХХҮГ, СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв, ХЭДС,	Ажилгүй иргэдийн 70-аас доошгүй хувийг ажлын байранд зуучлан бүсчилсэн хэлбэрээр "Хөдөлмөрийн яармаг"-ийг жил бүр зохион байгуулж хэвшсэн байна.
10	Аймгийн зарим сумдын орлого багатай малчин өрхүүдээс жил бүр 20-30 өрхийг "Малжуулах төсөлд" хамруулах, малгүй иргэдийг туслах аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор худаг ус гаргах, хадлан тэжээл бэлтгэх, хашаа, хороо барих зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай олон нийтийг хамарсан арга хэмжээг түлхүү зохион байгуулна.	ХХҮГ, СЗДТГ	2016-2020	Улс, ОНТөсөв, ХЭДС, 90,0 сая	Жил бүр 25-аас доошгүй малчин өрхийг малжуулан, ажлын байраар хангасан байна.
<b>1.5.3 Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, ажлын байрны эмх цэгцгийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг ханган бодлого хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, бүх шатанд нийгмийн зөвшлийн 2 болон 3 талт гэрээг /хамтын гэрээ/ байгуулан ажиллана.</b>					
1	Аймгийн АОЭХ-оос 2 жил тутамд нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулан бизнес эрхлэгчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, ЭМНДХ, АОЭХ, СЗДТГ	2016-2020	Орон нутгийн хөгжлийн сан 10,0 сая	Нэгдсэн зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж зарим тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэсэн байна.
